*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*2 дугаар хавсралт*

# ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДАХИН ЗАГВАРЧЛАЛЫН ХЭЛТСИЙН ДЭМЖИХ СИСТЕМ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ЛХАМСҮРЭН ОВОГТОЙ ЛХАМДУЛАМЫН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Төрийн цахим үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх нэгдсэн бодлого төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангана.** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1** “Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам”-ын батлагдсан хувилбарыг эрх бүхий байгууллагад хянуулж, бүртгүүлэхээр хүргүүлнэ. | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | - | 1 | “Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам”-ын төслийг боловсруулж дууссан. Эрх бүхий байгууллагад хянуулж, бүртгүүлэхтэй холбоотой тушаалын төсөл Сайдаар хянуулах шатанд явж байна. | 01-06 | 90 |
| | Яамны төлөвлөгөөний 50. **Арга хэмжээ 1.2.** Төрийн үйлчилгээг хиймэл оюун ухааны тусламжтайгаар хүсэлт шийдвэрлэх чадавх бүхий “Ухаалаг E-Mongolia” системийг хөгжүүлнэ. | Хөгжүүлж нэвтрүүлсэн хувилбар | - | 1 | Нээлттэй тендер зарласан ба 2 оролцогч санал ирүүлсэн нь шаардлага хангаагүй тул дахин зарласан. Ирэх 2025 оны 6 дугаар сарын 17-ны өдөр нээнэ. | 01-12 | - |
| | **Арга хэмжээ 1.3.** geree.gov.mn системийг сайжруулж хөгжүүлэхэд тухай бүр санал өгнө. | Саналын тоо | - | 1 | Цахим системийн хөгжүүлэлттэй холбоотой саналыг тухай бүр Үндэсний Дата төв УТҮГ-т хүргүүлж | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажилласан. Цахим системээр нийт 270 гэрээ баталгаажсан. | | |
| | **Арга хэмжээ 1.4.** Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн а/64 тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлалыг сайжруулах санал боловсруулна. | Саналын тоо | - | 1 | Тайлант хугацаа болоогүй. | 07-12 | - |
| | **Арга хэмжээ 1.5.** Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн үйлчилгээний шалгуур үзүүлэлтийг боловсруулна. | Боловсруулсан баримт бичгийн тоо | - | - | Тайлант хугацаа болоогүй. | 07-12 | - |
| **Зорилт 2. Нийтийн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулна.** | | | | | | | |
| 2 | **Арга хэмжээ 2.1.** Хүн, хуулийн этгээдийг төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-д холбох ажлыг зохион байгуулах | Шинээр холбогдсон хүн, хуулийн этгээдийн тоо | - | 100 | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам"-ын дагуу ХУР системд 175 гэрээ цахим системээр байгуулагдсан.<br>Төрийн мэдээлэл солилцооны үндсэн "ХУР" системд төрийн 172, хувийн хэвшлийн 462 байгууллага, нийт 634 байгууллага холбогдсон байна. | 01-12 | 100 |
| | Яамны төлөвлөгөөний 59.<br>**Арга хэмжээ 2.2.** Хүн, хуулийн этгээдийг танилт, нэвтрэлтийн систем (ДАН)-д | Шинээр холбогдсон хүн, хуулийн | - | 50 | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Үндсэн системийн үйл ажиллагааг | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | холбох ажлыг зохион байгуулна. | этгээдийн тоо | | | зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам"-ын дагуу 2025 оны хагас жилийн байдлаар Танилт, нэвтрэлтийн нэгдсэн систем (ДАН)-д төрийн 98 байгууллагын 188, хувийн 276 байгууллагын 325 систем бүртгэлтэй 2,220,683 иргэн байна.<br>Хүн, хуулийн этгээдийг танилт, нэвтрэлтийн систем (ДАН)-д II-р улирлын байдлаар нийт 81 гэрээ цахимаар байгуулагдсан. | | |
| | **Арга хэмжээ 2.3.**<br>Төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем (ХУР)-д холбогдох үйлчилгээ (сервис)-ний тоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна. | Шинээр нийлүүлсэн сервисийн тоо | - | 812 | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 196 дугаар тогтоолоор баталсан "Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 85 сервис үйлчилгээг шинээр хөгжүүлэн, холбох ажлыг зохион байгуулж, 2025 оны эхний хагас жилийн байдлаар 855 сервис үйлчилгээ холбогдсон. | 01 - 12 | 100 |
| | Яамны төлөвлөгөөний 72.<br>**Арга хэмжээ 2.4**<br>Албан бичиг солилцооны дундын системийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна. | Байгууллагын тоо | - | 485 | Цахим аймаг" бодлогын зөвлөмжийг орон нутагт хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх зорилго бүхий ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/22 дугаартай тушаалаар байгуулсан.<br>Энэхүү ажлын хүрээнд төрийн албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг 21 аймагт зохион байгуулж, сургалтын агуулгад албан бичиг солилцооны | 01 - 12 | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | дундын системийн хэрэглээний талаар тусгасан. Сургалтад төрийн 3,161 албан хаагч хамрагдсан.<br>2025 оны эхний хагас жилийн байдлаар 2757 байгууллага албан бичиг солилцооны дундын системд холбогдсон байна. | | |
| **Зорилт 3. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах зорилтын хүрээнд"** | | | | | | |
| 3 | **Арга хэмжээ 3.1.**<br>Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | ХАСХОМ бөглөх болон хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан баримтын тоо | - | Тухай бүр | Албан үүргийн дагуу шийдвэрийн төсөл боловсруулах, төрийн байгууллага болон хүн хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэхдээ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг мөрдөж ажилласан. | 01-12 | 100 |
| | **Арга хэмжээ 3.2.**<br>Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журамд заасан хугацаанд боловсруулж батлуулах, тайлагнах | Төлөвлөгөөний тоо Тайлангийн тоо | - | Тухай бүр | Гүйцэтгэлийн төлөвлөгөөг I-р улиралд батлуулсан.<br>- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 7 хоног, сар, I, II улирлаар тайлагнасан. | 01-12 | 100 |
| | **Арга хэмжээ 3.3.**<br>Чиг үүргийн дагуу төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь чанартай гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | Хэрэгжилтийн тайлан хүргүүлсэн эсэх | - | Тухай бүр | Чиг үүргийн дагуу төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь чанартай гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд тухай бүр хүргүүлсэн болно. | 01-12 | 100 |
| | **Арга хэмжээ 3.4.** | Албан бичгийг | - | Тухай бүр | Эхний хагас жилд нийт ирсэн-69<br>Шийдвэрлэсэн- 59 | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Байгууллагуудаас ирүүлсэн албан бичигтэй тухай бүрд нь танилцаж, хариу хүргүүлэх | тухай бүр шийдвэрлэс эн эсэх | | | Судлагдаж байгаа -10 | | |
| | **Арга хэмжээ 3.5.** Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэх | Шийдвэрлэс эн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн тоо | - | Тухай бүр | Үндсэн болон дэмжих системд холбогдох гэрээ байгуулах, сервис үйлчилгээ авах талаарх иргэн, хуулийн этгээдийн хүсэлтэд тухай бүр зөвлөгөө, мэдээлэл хүргэсэн. Цахим шуудангаар 1183 хариу мэдээлэл өгсөн байна. | 01-12 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | **Үүрэг даалгавар 1.** /ЦХИХХЯ/ УТ2506700069/1 тендерийн гэрээг байгуулах | Батлагдсан гэрээ | - | 1 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн батлах тухай” А/01 дугаар тушаалын “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарын тоног төхөөрөмж” /Улсын хэмжээнд/ УТ2506700069/1 тендерийн гэрээг байгуулах “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарын тоног төхөөрөмж улсын хэмжээнд” бараа нийлүүлэх гэрээ тендерийн гэрээг 2025 оны | 06 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 06 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 1.** Эрхэлсэн ажлын чиглэлээр олон улсаас зохион байгуулагдах сургалт, хурал, семинарт оролцох | Сургалтад хамрагдсан тоо | - | 1 | Дэлхийн банкнаас Ухаалаг засаг 2 төслийн багийн ахлагч болон холбогдох албан тушаалтнууд 2025.04.21-25-ны өдрийн хооронд Монгол улсад айлчлал хийж төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтарсан уулзалт зохион байгуулсан. | 01-12 | 100 |
| 2. | **Арга хэмжээ 2.** Дотоодод зохион байгуулагдах сургалт, хурал, семинарт оролцох | Сургалтад хамрагдсан тоо | - | 1 | “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулсан мод тарих үйл ажиллагаанд 2024 оны 05 дугаар 21-ний өдөр оролцсон. | 01-12 | 100 |
| 3. | **Арга хэмжээ 3.** Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 сургалтад хамрагдах | Сургалтад хамрагдсан тоо | - | 1 | Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 сургалтад 2025 оны 01 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд хамрагдсан. 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр шалгалт өгсөн. | 01-12 | 80 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДАХИН ЗАГВАРЧЛАЛЫН ХЭЛТСИЙН ДЭМЖИХ СИСТЕМ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

/ ............................ /

( Л.Лхамдулам )

2025.06.09
......... ......... .........